**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 13 өдөр                Дугаар А/10                Арвайхээр

Өвөрхангай аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. "а", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай" 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг нэгдүгээр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбар хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан тогтоож, бэлтгэл ажлыг сайтар хангаж зохион байгуулахыг салбар хороодын дарга нарт даалгасугай.

3.Сум, байгууллага бүр ойг угтсан бүтээлч ажлуудыг өрнүүлж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг сумдын Засаг дарга, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА                                А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн А/10 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН 90 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ |
|---|---|
| | **Удирдлага зохион байгуулалт, ёслол хүндэтгэл хариуцсан салбар хороо** |
| 1. | Монгол улсын хөгжлийн түүхийн үе шатуудад Өвөрхангайчуудын оруулсан оюуны хөрөнгө оруулалт, бүтээлч хөдөлмөр зүтгэлийг төр засгаас үнэлүүлэх зорилгоор төрөлх аймгаа Сүхбаатарын одонд тодорхойлно. |
| 2. | 90 жилийн ойн Лого, дурсгалын тэмдэг, Хүндэт медаль, хандивлагч болон өрх бүрт өгөх бэлэг, дурсгалын зүйлсийн загварыг тус тус гаргана. |
| 3. | Хөдөлмөрийн гарамгай амжилт гаргасан шилдэг тэргүүний 90 иргэнийг төрийн дээд одон медальд, салбар бүрээс 1 хүнийг гавьяатад тодорхойлно. |
| 4. | Улаанбаатар хотод зарим аймгуудад хандивлагч, хөрөнгө оруулагчдын зөвлөгөөн зохион байгуулж, аймгийн нийт байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд “Хандивын хөдөлгөөн” өрнүүлнэ. |
| 5. | “Өвөрхангайн түүх, өв соёл”, “Эдийн засгийн хөгжил” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулж, эмхэтгэл ном хэвлүүлнэ. |
| 6. | Өвөрхангай аймгийн хөгжил дэвшлийг харуулсан баримтат кино, түүхэн ном, “Тайлбар толь”, “Нутгийн удирдлага” номыг шинэчлэн бүтээнэ. |
| 7. | Аймаг байгуулагдсан өдрийг тусгай хөтөлбөр гарган тэмдэглэн өнгөрүүлэх, уг өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүндэтгэлийн хуралдааныг зохион байгууна. |
| 8. | Аймгийн музейн үзмэрүүдээр аймгийн түүхэн хөгжил замналыг харуулсан үзэсгэлэнг гаргана. |
| 9. | Аймгийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг харуулсан “Статистикийн товчоон” ном хэвлэн гаргана. |
| 10. | Аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн өмнө “Нэг зуун арван найман мянга дахь иргэн”-ээ албан ёсоор бүртгүүлж, алдаршуулах арга хэмжээг зохион байгуулна. |
| 11. | Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн “Баярын хурал”, төрийн дээд одон медаль, аймгийн ойн хүндэтгэлийн медаль гардуулах ажлыг тус тус зохион байгуулна. |
| 12. | Сумдын зарим төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг нутгийн уугуул алдартнуудын нэрэмжит болгож алдаршуулах ажлыг зохион байгуулна. |
| 13. | Өвөрхангай аймаг анх байгуулагдсан “Түйн голын цагаан эрэг”-дэх дурсгалын газрыг тохижуулж, бэсрэг наадам зохион байгуулна. |
| 14. | Уламжлалт монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, төрийн бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж болон гудамж, зам, талбайг “Монгол-Крилл бичиг”-ээр хаягжуулах ажлыг зохион байгуулна. |
| 15. | “Торгоны зам-Хархорум хот”, “Сарлагын баяр”, “Адууны баяр”, “Монгол эсгий урлалын баяр”, “Тэмээний баяр”, “Мөсний баяр” зэрэг орон нутгийн онцлогийг харуулсан эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулна. |
| 16. | Ойн хүрээнд зохион байгуулагдсан бүх арга хэмжээний материалыг цахим болон цаасан /ойн хүрээнд хийгдсэн телевизийн нэвтрүүлэг, ном, CD гэх мэт/ хэлбэрээр нэгтгэж аймгийн архивт шилжүүлнэ. |
| | **Соёл, урлаг, хэвлэл, мэдээлэл, сурталчилгаа** |

| | |
|---|---|
| 1. | Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн аймгийн баяр наадмын хөтөлбөрийг гаргана. |
| 2. | Аймгийн гаралтай зураач урчуудын нэгдсэн үзэсгэлэн гаргаж, бүтээлүүдээр нь зурагт альбом бүтээнэ. |
| 3. | Ойн хүрээнд хүүхэд залуучуудын дунд аймгийн түүх, өв соёлыг сурталчилах зорилгоор төрөл бүрийн соёл, урлагийн уралдаан, тэмцээнүүдийг зохион байгуулна. |
| 4. | Хүүхэд багачуудад зориулсан танин мэдэхүйн “Миний Өвөрхангай” ном хэвлэн гаргаж, хичээлийн хөтөлбөр боловсруулан аймаг байгуулагдсан тэмдэглэлт өдрөөр ерөнхий боловсролын сургуулиудад нэгэн зэрэг хичээл орно. |
| 5. | Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн “Хүндэтгэлийн концерт”-ыг бэлтгэн зохион байгуулна. |
| 6. | Аймгийн түүх, өв соёл, онцлог бахархалыг харуулсан төрөл бүрийн телевизийн нэвтрүүлэг бэлтгэж, төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр жилийн турш сурталчилна. |
| 7. | Өвөрхангай аймагтай холбогдолтой шилдэг дуу, шүлгийн уралдаан зарлаж, шалгарсан дуу, шүлгийг дүрсжүүлж, нийтийн хүртээл болгоно. |
| 8. | Улаанбаатар хотод аймаг сурталчлах соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулна. |
| 9. | Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулан ойн арга хэмжээнүүдийг тогтмол сурталчилна. |
| | **Санхүү, аж ахуй хариуцсан салбар хороо** |
| 1. | Аймгийн 90 жилийн ойн Лого, дурсгалын тэмдэг, Хүндэт медаль, урилга, хөтөлбөр хэвлүүлэх, ойн бэлэг дурсгалын зүйлс бэлтгэж хүргүүлэх ажлыг зохион байгуулна. |
| 2. | Ойн арга хэмжээнд урих зочид төлөөлөгчдийн судалгааг гаргаж, урилга хөтөлбөр хүргүүлэх ажлыг зохион байгуулна. |
| 3. | Аймгийн хэмжээнд үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйлчилгээний ажилтнуудын ур чадварыг сайжруулах, үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, ойн үйл ажиллагаанд оролцох үйлчилгээний ажилтан, хөтөчийг бэлтгэж сургаж, дадлагажуулна. |
| 4. | Ойн арга хэмжээнд урилгаар хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдийг байрлуулах байрны судалгааг гаргаж захиалга өгч бэлтгүүлэх, Дайргын голд зочид төлөөлөгчдийг хүлээн авах гэр хотхоныг байгуулж, шаардлагатай тог цахилгаанаар хангаж төрийн байгууллагуудад хуваарилан хариуцуулж ажиллуулна. |
| 5. | Амьжиргааны түвшингээс доогуур орлоготой, орон гэргүй 90 өрхөд гэр олгож амьжиргааг нь дэмжинэ. |
| 6. | Аймгийн 90 жилийн ойн хүрээнд 90 залуу гэр бүлд шинээр гэр олгох ёслолын ажиллагааг зохион байгуулна. |
| 7. | Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах бусад салбар хорооны бүрэлдэхүүн, ойн арга хэмжээнд шаардагдах төсөв, зардлыг боловсруулан батлуулна. |
| 8. | Ардын хувьсгалын 100, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн хүндэтгэлийн хүлээн авалт зохион байгуулна. |
| 9. | Ойн баяр наадмыг зохион байгуулахад шаардлагатай зарим материал, бүтээгдэхүүнийг хуваарилан өгч сумдаар бэлтгүүлэх ажлыг зохион байгуулна. |
| 10. | Ойн баяр наадмыг зохион байгуулахад гарсан зардлын тооцоо, анхан шатны баримтыг бүрдүүлж, хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ, дүгнэлт гаргуулна. |

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 13 өдөр Дугаар А/10 Арвайхээр

Өвөрхангай аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. "а", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 90 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай" 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг нэгдүгээр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий салбар хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хугацааг нарийвчлан тогтоож, бэлтгэл ажлыг сайтар ханган зохион байгуулахыг салбар хороодын дарга нарт даалгасугай.

3.Сум, байгууллага бүр ойг угтсан бүтээлч ажлуудыг өрнүүлж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг сумдын Засаг дарга, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2021 оны 01

дугаар сарын 15-ны өдрийн А/10 дугаар

захирамжийн хоёрдугаар хавсралт

# АЙМГИЙН 90 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

## 1.1.Удирдлага зохион байгуулалт, ёслол хүндэтгэл хариуцсан салбар хороо

Дарга: И.Доржсүрэн –аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Н.Энхцэцэг –аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Т.Гончигдорж –аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

М.Дэлгэрсайхан -аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Э.Бадамгэрэл -аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ч.Батсуурь -аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Удвал -аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Навчаа - аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

С.Долгорсүрэн -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Осоржин -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

## 1.2.Соёл, урлаг, хэвлэл, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан салбар хороо

Дарга: С.Ундрах –аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Сайнжаргал -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Ж.Пүрэвсүрэн –аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга

Л.Пүрэвлхам -аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Соёл урлагийн хэлтсийн дарга

Д.Түмэнжаргал -аймгийн Хөгжимт драмын театрын дарга

Н.Гуамарал -аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Энхцэцэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Н.Баярцэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн

Э.Дашзэвэг –аймгийн Хөгжимт драмын театрын ерөнхий найруулагч

Б.Батчимэг –Хэвлэл, мэдээллийн ажилтан

### 1.3.Санхүү, аж ахуй хариуцсан салбар хороо

Дарга: Ц.Ганболд -аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: -аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд: Т.Үржинпүрэв -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
А.Отгонцэцэг - аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Б.Нацаг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга
Ц.Нэргүй -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга
Р.Цэрэндэжид -аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Р.Наранцэцэг -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Бүзмаа -аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
С.Ганчимэг -Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга
О.Цэрэнчимэд -аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүч
Ц.Баяраа -аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

### 1.4.Наадмын талбайн засвар, тохижилт, үйлчилгээ хариуцсан салбар хороо

Дарга: Б.Ганбат - Арвайхээр сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга: Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд: С.Дуламсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга
Л.Ганзориг -Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын байцаагч
С.Цэдэнсодном -Арвайхээр хотын Захирагчийн албаны менежер
Д.Ганзориг -Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын нярав
Ц.Хоролсүрэн -"Онги-Ус суваг" орон нутгийн өмчит хувьцаат компанийн захирал
Б.Дэмбэрэлсайхан -Эрдэнэт-Булганы цахилгаан түгээр сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн салбарын ахлах инженер
Д.Сүх-Өлзий –"Арвайхээр сумын Тохижилт, үйлчилгээ" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга
Д.Мягмар –Арвайхээр-цэцэрлэгжилт орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга
Б.Бат-Эрдэнэ –"Арвайхээр гэрэлтүүлэг" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

-оОо-